Тухайн онд 90,172.8 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 9,860.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар, 110,395.60 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, 1,934,612.6 мянган төгрөгийн хөрөнгийг бусад байдлаар авч хөрөнгөд бүртгэсэн бөгөөд үндсэн хөрөнгийн зарцуулалтын хөдөлгөөн хийгдээгүй байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	2,145,041.0	Хасагдсан	0.00
Худалдан авсан	90,172.8	Худалдсан	
Хандиваар	9,860.0	Акталсан	
Шилжүүлэн авсан	110,395.6	Шилжүүлсэн	
бусад	1,934,612.6	Бусад	

Эх сурвалж: Бууцагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 25,165.3 мянга, эцсийн үлдэгдэл 14,237.6 мянган төгрөг болж 10,927.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	25,165.3	14,237.6	-10,927.7	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	1,299.1	1,097.1	(202.0)	7.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	23,866.2	13,134.3	(10,731.9)	92.3
Хувь хүмүүст төлөх өглөг		6.2	6.2	0.0
Дүн	25,165.3	14,237.6	(10,927.7)	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 14,237.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд ЭМД-ын санхүүжилт дутуу орсонтой холбоотой сумын Эрүүл мэндийн төвийн өглөг 8,493.5 мянган төгрөг буюу 59.6 хувь, Засаг даргын Тамгын газрын тээвэр шатахуун, бусад зардлын тооцооны өглөг 3,422.5 мянган төгрөг буюу 24 хувь, Цэцэрлэг түлш халаалтын зардлын 2,156.3 мянган төгрөг буюу 15 хувийг эзэлж байгаа нь голлох нөлөө үзүүлж байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ЗДТГ	2,113.8	3,422.5	1,308.7	24.0
Соёл	87.5		(87.5)	-
ЭМТ	0.1	8,493.5	8,493.5	59.7
ЕБС	22,102.5	87.0	(22,015.5)	0.6
Цэцэрлэг	192.6	2,156.3	1,963.7	15.1

**Бууцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Багийн цэцэрлэг		42.0	42.0	0.3
Бага сургууль	668.7	36.3	(632.4)	0.3
ДҮН	25,165.2	14,237.6	(10,295.2)	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 14,911,057.4 мянга, эцсийн үлдэгдэл 16,524,761.6 мянган төгрөг болж, 1,613,704.2 мянган төгрөгөөр өссөн тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,132,340.9	2,132,340.9	-	12.9
Өмч: - төрийн	2,132,340.9	2,132,340.9	-	12.9
Хуримтлагдсан үр дүн	9,753,833.2	11,367,537.4	1,613,704.2	68.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,024,883.3	3,024,883.3	-	18.3
Дүн	14,911,057.4	16,524,761.6	1,613,704.2	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн хуралдаанаар 2/05 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 70,600.0 мянга, хүү торгуулийн орлогыг 32,000.0 мянга, нийт 102,600.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	70,600.0	103,917.4	33,317.4	147.2
ИОТХ	12,500.0	36,632.8	24,132.8	293.1
Бууны татвар	2,000.0	2,701.4	701.4	135.1
Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	4,011.4	2,011.4	200.6
Хадгаламжийн хүүгийн орлого	40,000.0	48,605.1	8,605.1	121.5
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	3,000.0	2,509.2	(490.8)	83.6
Газрын төлбөр	1,600.0	373.6	(1,226.4)	23.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	9,000.0	9,083.9	83.9	100.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.0		(500.0)	-
2.Татварын бус орлого	32,000.0	38,657.2	6,657.2	120.8
2.1.Хүү торгуулийн орлого	32,000.0	38,657.2	6,657.2	120.8
Нийт дүн	102,600.0	142,574.6	39,974.6	139.0

Эх сурвалж: Бууцагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 39,974.6 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон татварын орлого 24,132.8 мянга, улсын тэмдэгтийн хураамж 2,001.4 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 6,974.6 мянга, бууны татвар 701.4 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 83.3 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин газрын төлбөр 76.6 хувь буюу 1,226.4 мянга, Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 76.6 хувь буюу 490.8 мянга, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 100 буюу 500.0 мянган төгрөгийн орлого тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 350.0 мянган төгрөгийн орлого орсон байна.

Бууцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 100,000.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 81,529.8 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

3.5.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн 8 хөтөлбөрт 3,483,540.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,206,883.8 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 3,126,351.2 урсгал зардалд зарцуулсан бол 123,896.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 7 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнд ноогдох хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.18-ний өдрийн 2/05 дугаар тогтоолоор нийт 3,315,158.6 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	148,783.1	108,736.5	40,046.6
Засаг даргын Тамгын газар	465,501.8	406,533.7	58,968.1
Сургууль	1,743,150.7	1,236,482.6	506,668.1
Цэцэрлэг	515,739.6	455,937.9	59,801.7
Эрүүл мэндийн төв	588,759.6	598,446.4	-9,686.8
Соёлын төв	147,899.8	106,071.3	41,828.5
Бага сургууль	224,520.0	114,772.2	109,747.8
Багийн цэцэрлэг	92,805.3	55,030.8	37,774.5
Сум хөгжүүлэх сан		100,000.0	-100,000.0
Орон нутгийн хөгжлийн сан		133,147.2	-133,147.2
Нийт дүн	3,927,159.9	3,315,158.6	612,001.3

Эх сурвалж: Бууцагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн 2/05 дугаар тогтоолоор анх 3,315,158.6 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2021.03.09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 86,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 76,980.0 мянга, 39,053.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлснээр сумын нийт төсөв 3,517,192.1 мянган төгрөг болсон бөгөөд сумын ИТХ-ын хуралдаанаар төсвийг нэмж батлаагүй байна.

Нийт зардлын 2,086,576.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 942,698.1 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 102,600.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 101,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 37,170.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 123,147.2 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, ОНХС-ын үлдэгдлээс 10,000.0 мянга, 114,000.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

**Бууцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 2,086,576.0 мянга, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтээр 1,146,159.5 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээр 123,896.4 мянга, туслах үйл ажиллагааны орлогоор 416.0 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 16,502.2 мянган төгрөгийг санхүүжилт авч улсын төсөвт 39,713.8 мянга, орон нутгийн төсөвт 3,556.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улсын төсөвт төвлөрүүлсэн	ОН төсөвт төвлөрүүлсэн
ИТХ	119,036.5	119,036.5	0.0	100.0		264.2
ЗДТГ	459,427.7	458,743.7	684.0	99.9		716.5
Сургууль	1,367,785.9	1,364,710.4	3,075.5	99.8	16,804.9	
Цэцэрлэг	438,020.3	434,313.0	3,707.3	99.2	1,322.9	
Соёлын төв	107,596.8	108,096.8	-500.0	100.5		2575.3
Хүн эмнэлэг	598,446.4	571,468.29	26,978.1	95.5	19,696.9	
Бага сургууль	133,769.0	133,359.0	410.0	99.7	7.1	
Багийн цэцэрлэг	59,962.3	59,826.1	136.2	99.8	1,882.0	
СХСан	100,000.0	100.0	99,900.0	0.1		
ОНХСан	133,147.2	123,896.4	9,250.8	93.1		
Нийт дүн	3,517,192.1	3,373,550.2	143,641.9	95.9	39,713.8	3,556.0

Эх сурвалж: Бууцагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 16,804.9 мянга, Цэцэрлэгийн зардлыг 1,322.9, Баянбүрдийн цэцэрлэгийн зардлыг 1,882.0, Соёлын төвийн зардлыг 2,575.3 мянга, ИТХ-ын зардлыг 264.2 мянга, ЗДТГ-ын зардлыг 716.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 145,580.4 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 94,282.6 мянга, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос 231,109.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнээс тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 39,744.8 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 68,841.4 мянга, Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд 31,000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 268,694.8 мянга, хангамжийн материалын болон бараа үйлчилгээний зардал 4,594.2 мянган төгрөгийг зарцуулж 58,096.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

**Бууцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	Соблын төв	Бага сургууль	Багийн цэцэрлэг	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	1,000.0	93,067.9	53,209.9	14,252.8	285,999.8	0.0	18,385.4	5,056.2	470,972.0
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.0	0.0	53,209.9	14,252.8	53,676.1	0.0	18,385.4	5,056.2	145,580.4
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	93,067.9	0.0	0.0	1,214.7	0.0	0.0	0.0	94,282.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	0.0	0.0	0.0	0.0	231,109.0	0.0	0.0	0.0	231,109.0
НИЙТ ЗАРЛАГА	998.5	34,979.3	52,915.7	14,252.8	284,778.4	1,214.7	14,085.4	5,056.2	412,875.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	998.5	34,979.3	0.0	0.0	231,502.3	1,214.7	0.0	0.0	268,694.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	0.0	0.0	0.0	31,000.0	0.0	0.0	0.0	31,000.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	0.0	25,659.5	0.0	0.0	0.0	14,085.4	0.0	39,744.8
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	0.0	27,256.2	14,252.8	22,276.1	0.0	0.0	5,056.2	68,841.4
Хангамж, бараа материалын зардал	0.0	0.0	294.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	294.2
Эд холшил урсгал засварын зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	2,500.0	0.0	2,500.0
Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	1,800.0	0.0	1,800.0
Төсөвт төвлөрүүлсэн	1.5	58,088.5	294.2	0.0	1,221.4		4,300.0	0.0	58,096.7

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын Засаг даргын нөөц санг 56,995.0 төгрөгөөр тодотгон баталж, бүрэн зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 67.7 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд ковид цар тахал, малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 15,048.4 төгрөг буюу 27,0 хувийг 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд 34,969.7 төгрөг буюу 61,0 хувийг, 2.1.6 дахь заалтын хүрээнд шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт 4,931.5 төгрөгийг тус тус зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Тус сумын Засаг даргын ажлын алба нь сумын Засаг даргын Тамгын газар байна. Жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 9 үндсэн зорилтын хүрээнд 89 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 95,2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 3,517,192.1 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 3,330,280.4 мянган төгрөгийг зарцуулж, 94.6 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 9 нэр төрлийн орлогоор 102,900.0 төгрөг төвлөрүүлэхээс 142,574.6 төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 139 хувь буюу 39,974.6 мянган төгрөгөөр давж биелсэн боловч 3 нэр төрлийн орлого 2,217.2 төгрөгөөр төлөвлөснөөс тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Бууцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бууцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 8 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Бууцагаан сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс
ЕБСургууль	1	1	1		1	1			
Хүүхдийн цэцэрлэг	1	1	1		1	1			
ЗДТГ	1	1	1		1		1		
ИТХурал	1	1		1					
Соёлын төв	1	1		1					
ЭМТ	1	1	1		1	1			
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					
Бага сургууль	1	1		1					
Багийн цэцэрлэг	1	1		1					
НИЙТ ДҮН	10	10	4	6	4	3	1	0	0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 8 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллагыг түүвэрт хамруулсан ба аудитад хамрагдсан байгууллагуудаас ЗДТГ нь тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр өвс авахаар Навка ХХК-тай гэрээ байгуулж 21,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн 10,000.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж түүнээс үүссэн хоорондын тооцооны авлага 11,000.0 мянга, иргэдэд зээлээр өгсөн өвсний үнэ 9,400.0 мянган төгрөгийн авлагыг тус тус санхүүгийн тайланд тусгаагүй, сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд 134,996.5 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага байгаагаас 55,260.6 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрснийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг үндэслэлээр хязгаарлалттай санал дүгнэлт өгч бусад байгууллагуудад зөрчилгүй санал дүгнэлтийг өгсөн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 178,567.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,816.9 сая төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулж, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлэн, 17,233.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтож, 156,516.7 мянган төгрөгийн 12 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ИТХ	1	394.5			1	394.5				
ЗДТГ	6	22,188.4	1		1	115.0	1		3	22,073.4

**Бууцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

ЕБСургууль	3	5,567.4			2	3,607.4			1	1,960.0
Хүүхдийн цэцэрлэг	4	11,508.3	3	4,816.8	1	6,691.5				
Бага цэцэрлэг	2	641.8			2	641.8				
ЭМТ	2	5,783.6			2	5,783.6				
СХС	1	4,723.0							1	4,723.0
СТА зөрчлийн дүн	19	50,807.0	4.0	4,816.8	9.0	17,233.8	1.0	-	5	28,756.4
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЗДТГ	3	73,804.9							3	73,804.9
ЕБСургууль	1	35,255.0							1	35,255.0
Соёлын төв	1								1	-
Хүүхдийн цэцэрлэг	1	4,615.1							1	4,615.1
Бага сургууль	1	14,085.4							1	14,085.4
Нийцлийн аудитын дүн	7	127,760.4	-	-	-	-	-	-	7	127,760.4
Нийт дүн	26	178,567.4	4	4,816.80	9.0	17,233.8	1	-	12	156,516.8

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 50,806.9 мянган төгрөгийн 19 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 127,760.4 мянган төгрөгийн 7 зөрчил тус тус илэрсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 155 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	мэдээлээгүй
1	Бүтэн жил	12	12	12		
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	8		

**Бууцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

4	Сар бүр	5	60	60		
5	Тухай бүр	6	72	72		
Нийт		28	155	155	0	0

Эх сурвалж. Бууцагаан сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Бууцагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Бууцагаан сумын ЕБС нь тайлант онд 1,367,785.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 1,347,905.5 төгрөгийг зарцуулж оны эцэст 19,880.4 мянган төгрөг буюу төсвийн 2.5 хувийг буцаан төвлөрүүлсэн, мөн хэмнэгдсэн зардлаас гүйлгэн зарцуулж 35,255.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.8 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
- Бууцагаан сумын Хүүхдийн Цэцэрлэг нь тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 41,612.1 мянган төгрөг батлагдсан ба батлагдсан төсвийн 20 хувь нь 8,322.4 мянган төгрөг байна. Төсвийн гүйцэтгэлээр 3,707.3 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна.
- Бууцагаан сумын ЗДТГ нь түлш, халаалтын 491.5 мянга, тээвэр шатахууны өглөг 1,351.9 мянга, үзэсгэлэнт Баянхонгор төслийн хүрээнд хийгдсэн видео контент, бичлэгийн ажлын хөлс 507.6 мянга, нийт 2,350.9 мянган төгрөгийн өр үүсгэн төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулсан.
- Мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 33,403.9 мянган төгрөгөөр баталж 32,799.4 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд нийт 6,680.7 мянган төгрөг хэмнэхээс 604,5 мянган төгрөгийг хэмнэж 6,076.2 мянган төгрөг хэмнээгүй зарцуулсан нь ЗГ-ын 43 тогтоолын 1.1, 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Иймд дээрх зөрчлүүдэд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 386,899.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 1а/231 дугаартай албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	3	386,899.4	3	386,899.4			100.0
Нийт	3	386,899.4	3	386,899.4			100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус сумын ЗДТГ-ын бараа материалын дансанд бүртгэлтэй 20,611.8 мянган төгрөгийн өвс тэжээл, ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд бэлтгэсэн өвс тэжээлийн орлого, зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Бууцагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар алдаа зөрчил давтан гаргахгүй 78,416.6 мянган төгрөгийн 6 зөвлөмжийг хүргүүлж байна.

4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалттай нийцүүлэн тайлагнаж байх, мөн хуулийн 64.1.3-т заасны дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлж батлуулж байх зөвлөмжийг хүргүүлэв.

2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт “Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалтын дагуу аймгийн Засаг даргын 2012.12.06-ны А/742 тоот захирамжаар сургуулийн төсвийг 57,900.0 мянга, бага сургуулийн төсвийг 12,700.0 мянга нийт 70,600.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн зохицуулалт хийсэн байхад сумын ИТХ-ын хуралдаанаар өөрчлөлтийг батлаагүй байна.

Өгсөн зөвлөмж: ТЭЗ-чийн шийдвэрээр төсөвт зохицуулалт хийсэн тухай бүр өөрчлөлтийг сумын ИТХ-ын хуралдаанаар батлуулж байх зөвлөмж өгөх

3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 178.567.3 мянган төгрөгийн 26 алдаа зөрчил илэрсэн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн толилуулгыг хугацаанд нь ирүүлээгүй, сүүлийн 2 жил дараалан сумын ЗДТГ нь өөрчлөлттэй дүгнэлт авсан байхад Санхүүгийн албаны дарга энэ талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын Засаг дарга санхүүгийн нэгтгэсэн тайлан болон ТШЗ-ийн санхүүгийн тайланд илэрсэн алдаа зөрчлийг арилгах талаар төлөвлөгөө гарган ажиллаж, санхүүгийн

Бууцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ажилтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлэх тал дээр анхаарч, арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөв.

4.УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр өвс бэлтгүүлэхээр Навка ХХК-тай 35,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 21,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн 1000 боодол өвсийг хүлээн авч үлдэгдэл 11,000.0 мянган төгрөгийн 1100 боодол өвсийг хүлээж аваагүй, иргэдэд зээлээр худалдан борлуулсан өвсний үнэ 9400.0 мянга, нийт 21,000.0 мянган төгрөгийн авлагыг хоорондын тооцоо нийлж баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.”Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.6. “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Оршин байх”, “Үнэн зөв байдал, Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ОНХС-гийн 2022 оны санхүүгийн тайланд 20400.0 мянган төгрөгийн өвсний тооцооны авлагыг бүртгэж 2022.05.01-ны дотор барагдуулж, худалдан авсан өвсний үлдэгдэл 600.0 мянган төгрөгийн өвсийг санхүүгийн тайланд тусгаж зарцуулсан тухай бүр нь мөнгийг дансанд бүрэн төвлөрүүлж байх

5.УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд 134,996.5 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага байгаагаас 55,260.6 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрснийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.7 дахь “Иргэн, хуулийн этгээд авсан, зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө”, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Оршин байх”, “Үнэн зөв байдал, Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж зээлийг хугацаанд барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах

6.УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тайланд онд хуулгаар орсон орлогын нэр төрлийг зөрүүтэй тайлагнаснаас 2021 оны санхүүгийн тайлангийн орлогын нэр төрөл 2,156.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, санхүүгийн тайлангийн “бодитой оршин байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогыг нэр төрөл тус бүрээр гаргаж санхүүгийн тайланд үнэн зөв илэрхийлж, Татварын байцаагчтай татварыг нэр төрлөөр тулгалт хийж баталгаажуулж байх талаар зөвлөмж өгөв.

**Бууцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Бууцагаан сумын ТТЗ	6	78,416.6							6	78,416.6
	Дүн	6	78,416.6							6	78,416.6
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Дүн										
	Нийт дүн	6	78,416.6							6	78,416.6

Хавсралт 1. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Бэлтгэх 1. Бууцагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар

Огноо	Аудитын нэр:	Бууцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:
2022.03.25			БНА-2022/6/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Бууцагаан сумын Засаг дарга		Мянган төгрөг

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
	Бууцагаан сумын Засаг дарга	78,416.6			
1	Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт "Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" гэсэн заалтын дагуу аймгийн Засаг даргын 2012.12.06-ны А/742 тоот захирамжаар сургуулийн төсвийг 57,900.0 мянга, бага сургуулийн төсвийг 12,700.0 мянга нийт 70,600.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн зохицуулалт хийсэн байхад сумын ИТХ-ын хуралдаанаар өөрчлөлтийг батлаагүй байна.		Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Лхагвадорж, Г.Энхтүвшин
2	Сум хөгжүүлэх зээлийн эргэн төлөлт хангалтгүй бөгөөд нийт авлагын 41 хувь буюу 55,260.6 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрснийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	55,260.6	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Лхагвадорж, Г.Энхтүвшин

**Бууцаган сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

3	Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.		Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Лхагвадорж , Г.Энхтүвшин
4	Тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр өвс бэлтгүүлэхээр Навка ХХК-тай 35,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 21,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн 1000 боодол өвсийг хүлээн авч үлдэгдэл 11,000.0 мянган төгрөгийн 1100 боодол өвсийг хүлээж аваагүй, иргэдэд зээлээр худалдан борлуулсан өвсний үнэ 9400.0 мянга, нийт 21,000.0 мянган төгрөгийн авлагыг хоорондын тооцоо нийлж баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй байна.	21,000.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Лхагвадорж , Г.Энхтүвшин
5	Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 178,567.3 мянган төгрөгийн 26 алдаа зөрчил илэрсэн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн толилуулгыг хугацаанд нь ирүүлээгүй, сүүлийн 2 жил дараалан сумын ЗДТГ нь өөрчлөлттэй дүгнэлт авсан байхад Санхүүгийн албаны дарга энэ талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.		Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Лхагвадорж , Г.Энхтүвшин
6	Тайланд онд хуулгаар орсон орлогын нэр төрлийг зөрүүтэй тайлагнаснаас 2021 оны санхүүгийн тайлангийн орлогын нэр төрөл 2,156.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	2,156.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Лхагвадорж , Г.Энхтүвшин

2. Бууцаган сумын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангаар

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
	Бууцаган сумын төсөвт байгууллагуудын зөрчлийн дүн	178,567.4			
	Бууцаган сумын ИТХ-ын дүн	394.5			
1	Бууцаган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 05 тоот тушаалаар Олон нийтийн цагдаа ажилтай Л. Цолмонбаатарыг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн байхад 336,550.00 төгрөг, сумын ИТХ-ын дарга Ш.Төмөрт 9 сард цалинг 57,694.00 төгрөгөөр илүү олгосон.	394.5	Төлбөрийн акт	Хурлын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Д.Эрдэнэдалай, Г.Ууганзаяа
	Бууцаган сумын ЗДТГ-ын дүн	95,993.3			
2	Тайлант оны санхүүгийн тайлангаар бусад хангамжийн материалын дансны эхний болон эцсийн үлдэгдлийг Сангийн яамны Э-тайланд аж ахуйн материал 35420 дансанд зөрүүлж шивсэн байна.	-	Сангийн яамны Э-тайланд үлдэгдлийг залруулав.	Тамгын газрын дарга Нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар Г.Ууганзаяа

**Бууцаган сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

3	Тус сумын Соёл амралтын хүрээлэнгийн автомат худгийг харж хамгаалах, ногоон байгууламжийг усалж ургуулах, эвдэрсэн хашаа, хамгаалалтыг засаж сэлбэх ажлыг гүйцэтгэхээр П.Батаатай 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 02 тоот гэрээг 2 жилээр байгуулж 950000 төгрөг олгосон байхад цалингаас татварыг суутган тооцоогүй. Байгууллагын даргын 2021 оны Б/08, Б/18 дугаар тушаалуудаар шинээр хүүхэдтэй болсон 2 ажилтанд олгосон тус бүр нь 100.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжаас ХХОАТ суутгаагүй байна.	115.0	Төлбөрийн акт	Тамгын газрын дарга Нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар Г.Ууганзаяа
4	Тус байгууллага хөрөнгө, аж ахуйн материалын тайланг 2021 оны 9 сарын байдлаар гаргаагүй, байгууллагын даргын 2021 оны А/19 дүгээр тушаалаар байгуулагдсан тооллогын комисс хөрөнгийн эхний хагас жилийн тооллого хийсэн боловч хөрөнгийг тооцоо бодсон актаар баталгаажуулж, үр дүнг тооцоогүй байна.		Албан шаардлага	Тамгын газрын дарга Нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар Г.Ууганзаяа
5	Санхүүгийн тайлангийн бараа материалын тусгай зориулалтын дансанд бүртгэлтэй 20,611.8 мянган төгрөгийн өвс тэжээлийн үнийг байгууллагын даргын шийдвэргүйгээр бараа материалын данснаас хассан байна.	20,611.8	Зөвлөмж өгсөн	Тамгын газрын дарга Нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар Г.Ууганзаяа
6	Сумын Санхүү албаны дарга 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдөр хийсэн 395.0 мянган төгрөгийн гүйлгээ нэр данс зөрүүтэй байснаас буцаж орсоныг бараа үйлчилгээний зардлаар бүртгэлгүй, томилолтын зардлаар хааснаас төсвийн гүйцэтгэлийн тайланд дээрх 395.0 мянган төгрөгөөр зардал хооронд зөрүү үүсэж тайлан буруу илэрхийлэгдсэн байна.	395.0	Зөвлөмж өгсөн	Санхүү албаны дарга	Г.Энхтүвшин
7	Тус байгууллага нь 2021 онд 614,428.8 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 549,051.0 мянган төгрөгийн 143 мэдээллийг хугацаандаа байршуулж 65,377.8 мянган төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроосон	65,377.8	Зөвлөмж өгсөн	Тамгын газрын дарга Нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар Г.Ууганзаяа
8	Тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 33,403.9 мянган төгрөгөөр баталж 32,799.4 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд нийт 6,680.7 мянган төгрөг хэмнэхээс 604.5 мянган төгрөгийг хэмнэж 6,076.2 мянган төгрөг хэмнээгүй.	6,076.3	Зөвлөмж өгсөн	Тамгын газрын дарга Нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар Г.Ууганзаяа
9	Тус байгууллага нь түлш, халаалтын 491.5 мянга, тээвэр шатахууны өглөг 1,351.9 мянга, үзэсгэлэнт Баянхонгор төслийн хүрээнд хийгдсэн видео контент, бичлэгийн ажлын хөлс 507.6 мянга, нийт 2,350.9 мянган төгрөгийн өр үүсгэн төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулсан.	2,350.9	Зөвлөмж өгсөн	Тамгын газрын дарга Нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар Г.Ууганзаяа
10	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өглөгийн эзэн холбогдогчийг тогтоож, авлага, өглөгийг бүрэн барагдуулж, орон нутгийн орлогод төвлөрүүлэх гэсэн зөвлөмж өгсөн боловч 1,066.5 мянган төгрөгийн өглөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй, өрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан баримт байхгүй байна.	1,066.6	Зөвлөмж өгсөн	Тамгын газрын дарга Нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар Г.Ууганзаяа
	Бууцаган сумын Ерөнхий боловсролын сургуулийн дүн	40,822.4			
11	Тогооч Н.Ганхөлөгийн амралтын цалинд 975.1 мянган төгрөг бодогдож 950.0 мянган төгрөгийг урьдчилж олгосон ба 155.3 мянган дутуу суутгаж санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.	155.3	Төлбөрийн акт	Сургуулийн захирал Нягтлан бодогч	Х.Болормаа, Д.Баярмаа

**Бууцаган сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

12	Тайлант онд дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 45,104.3 мянган төгрөгийн хоолны зардал гарч 11973 хүүхэд өдөр хамрагдаж 1 хүүхдэд ногдох нормативд зардал 1452 төгрөг буюу 3,452.1 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна.	3,452.1	Төлбөрийн акт	Сургуулийн захирал Нягтлан бодогч	Х.Болормаа, Д.Баярмаа
13	Тайлант онд 1,367,785.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 1,347,905.5 төгрөгийг зарцуулж оны эцэст 19,880.4 мянган төгрөг буюу төсвийн 2.5 хувийг буцаан төвлөрүүлсэн, мөн хэмнэгдсэн зардлаас гүйлгэн зарцуулж 35,255.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.8 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.	35,255.0	Зөвлөмж өгсөн	Сургуулийн захирал Нягтлан бодогч	Х.Болормаа, Д.Баярмаа
14	Тухайн байгууллага нь 2021 оны эцэст 2,328.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүний 1,960.0 мянган төгрөг нь эзэн холбогдогч нь нас барсан он удаан жил болсон авлага байна.	1,960.0	Зөвлөмж өгсөн	Сургуулийн захирал Нягтлан бодогч	Х.Болормаа, Д.Баярмаа
БУУЦАГААН БАГА СУРГУУЛЬ		14,085.4			
15	Шилэн дансанд байршуулвал зохих 109,644.0 мянган төгрөгийн 151 мэдээллээс 5 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 мэдээлэл мэдээлээгүй Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 14085.3 мянган төгрөгийн 1 мэдээлэл мэдээлээгүй байна.	14,085.4	Зөвлөмж өгсөн	Сургуулийн захирал Нягтлан бодогч	Ш.Уранчимэг, Д.Баярмаа
БУУЦАГААН СУМ СОЁЛЫН ТӨВ		-			
16	Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 108,021.3 мянган төгрөгийн 151 мэдээллээс 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.			Дарга, нягтлан бодогч	С.Мөнхтоогоо, Б.Золзаяа
Бууцаган сумын баян бүрд дөрөвдүгээр багийн хүүхдийн цэцэрлэг		641.8			
17	Сургуулийн захирлын 2021 оны 04.22-ны өдрийн Б/10 тушаалаар 1-р улирлын үр дүнгийн урамшууллыг 2021.04.06-нд олгосон байхад 6 сард давхардуулан 393,248 төгрөгийг олгосон байна.	393.2	Төлбөрийн акт	Сургуулийн захирал Нягтлан бодогч	Ш.Уранчимэг, Д.Баярмаа
18	Тайлант хугацаанд түлш халаалт, хоол, бусад хангамжийн материалын үнэнд 2,485,650 төгрөгийг шилжүүлэхдээ ХАОАТ суутгаагүй, е баримт хавсаргаагүй байна.	248.6	Төлбөрийн акт	Сургуулийн захирал Нягтлан бодогч	Ш.Уранчимэг, Д.Баярмаа
Бууцаган сум Сум хөгжүүлэх сан		4,723.0			
19	Тайлант оны эхэнд зээл зээлийн хүүгийн 212,995.8 мянган төгрөгийн авлагатай бөгөөд тайлант хугацааны эцэст 134996.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс хэтэрсэн 55260.6 мянган төгрөг байгаа бөгөөд шүүхэд шилжүүлсэн байна. Авлагын үлдэгдэлд 4722.9 мянган төгрөгийн нас барсан 2 зээлдэгчийн үлдэгдэл байна.	4,723.0	Зөвлөмж өгсөн	Сумын Засаг дарга, нягтлан бодогч	Д.Лхагвадорж, Б.Золзаяа
БУУЦАГААН СУМ ЦЭЦЭРЛЭГ		16,123.4			



**Бууцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

20	Багш ажилтнуудын хоолны зардлын төсөв батлагдаагүй байхад эрхлэгчийн 2021.10.22-ны Б/16, 2021.11.22-ны Б/18 тоот тушаалаар 1 ажилтанд 250.0 мянган төгрөгөөр бодож 11250.0 мянган төгрөг, /5750.0+5500.0/ тус тус олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, "тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай" Сангийн сайдын 2021.10.29-ний 190 тоот тушаалын хавсралтаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж цалингийн зардлаас хоолны хөнгөлөлт олгосон	6,691.5	Төлбөрийн акт	Эрхлэгч, нягтлан бодогч	Д.Гэрэлээ, Д.Мөнхтуяа
21	2021 оны 12 дугаар сарын халаалтын зардлыг 2156.8 мянган төгрөгөөр шилжүүлээд өглөгөөр тусгаагүй.	2,156.8	Санхүүгийн тайлангийн залруулга	Эрхлэгч, нягтлан бодогч	Д.Гэрэлээ, Д.Мөнхтуяа
22	2021.12.23-нд Жойфул дэсэндэнүс ХХК-иас төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1250.0 мянган төгрөгийн үнэтэй ус цэвэршүүлэгч, 1260.0 мянган төгрөгийн үнэтэй шүүлтүүр зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг хангамжийн материалд орлого авсан.	2,510.0	Санхүүгийн тайлангийн залруулга	Эрхлэгч, нягтлан бодогч	Д.Гэрэлээ, Д.Мөнхтуяа
23	Санхүүгийн тайланд программ хангамж түүний хуримтлагдсан элэгдлийг бусад биет бус хөрөнгөд бүртгэж тайлагнасан атлаа Э-тайланд программ хангамж дансанд бүртгэсэн зэргээс 4816.8 мянган төгрөгийн алдаа илэрсэн.	150.0	Санхүүгийн тайлангийн залруулга	Эрхлэгч, нягтлан бодогч	Д.Гэрэлээ, Д.Мөнхтуяа
24	Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 41,612.1 мянган төгрөг батлагдсан ба батлагдсан төсвийн 20 хувь нь 8,322.4 мянган төгрөг байна. Төсвийн гүйцэтгэлээр 3,707.3 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна.	4,615.1	Зөвлөмж	Эрхлэгч, нягтлан бодогч	Д.Гэрэлээ, Д.Мөнхтуяа
БУУЦАГААН СУМЫН ЭМТ		5,783.6			
25	ЭМТ-ийн төсөвт хоолны мөнгийг ажилласан өдөрт 1 хүнд 1000 төгрөгөөр тогтоон сар бүр олгосон байхад 2021.12.14-ны Б/53 дугаар тушаалаар ажилчдад хоолны мөнгөнд 4,906.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон	4,906.0	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Д.Сармандах, Д.Мөнхтуяа
26	Сумын Засаг даргын 2021.12.15-ны өдрийн б/56 дугаартай захирамжаар ЭМТ-ийн даргад эмчлэгч их эмчийн ажлыг 10,11,12 дугаар сард хавсруулан гүйцэтгүүлж нэмэгдлийг 40 хувиар тооцон олгох, 2021.12.15-ны өдрийн б/55 дугаартай захирамжаар ЭМТ-ийн даргад ур чадварын нэмэгдлийг 9,10,11 дүгээр сарынхыг нөхөж олгохоор шийдвэрлэсний дагуу 877.6 мянган төгрөгийг олгосон байна.	877.6	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Д.Сармандах, Д.Мөнхтуяа

оОо